



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ


Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 6-р сарын байдлаар 46.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 77.1 хувиар, зарлага 78.1 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 46.1 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 185.9 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 9.3 төгрөгөөр нэмэгдлээ.

Зургаадугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 222 төгрөг буюу 9.1 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 9.3 төгрөг буюу 0.35 хувиар нэмэгдэж 2654.47 төгрөг болов. 5-р сард гадаад валютын нөөц 3.7 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 1 хувиар буурсан бол, өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өсчээ.




Инфляцийн түвшин 9.6%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 6-р сарын байдлаар өмнөх сараас 1.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар, оны эхнээс 5.4 хувь өсөв. 9.6 хувиар хувиар өсөхөд хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, эм тарианы үнийн дүн нэмэгдсэн хэвээр байна.




Гадаад худалдааны тэнцэл 1045 сая.ам доллар болов.

2019 оны зургаадугаар сард нийт барааны эргэлт 6833 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 9.9 импорт өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1045 сая ам.долларын ашигтай гарлаа.



6-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2019 оны 6-р сард 13.8 их наяд төгрөг болж өмнөх сараас 346.8 тэрбум төгрөг буюу 3.1 хувиар буурав. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 18.1 хувиар буюу 2112 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 10936.4 тэрбум төгрөг буюу өмнөх сараас -3.1 хувиар буурсан бол валютын хадгаламж 2932.8 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.1 хувиар нэмэгджээ. Үүнээс төгрөгийн хадгаламж 79 хувь, валютын хадгаламж 21 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 18.1 хувиар нэмэгдсэн бол валютын хадгаламж 17.4 хувийг эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ 5.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР БОЛОВ

- Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн энэ оны зургаан сарын байдлаар, 8.3 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1.4 их наяд төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 5.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 953.6 (19.8 хувь) тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт 514.5 (29.8%) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 449.8 (17.2 хувь) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.
- ЕВРОПЫН ХОЛБОО 4.5 САЯ ЕВРО МОНГОЛ УЛСАД ЗАРЦУУЛЖ БАЙНА**
Европын холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP+) хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс жилд 6200 нэр төрлийн бүтээгдэхүүнийг Европын зах зээлд татваргүй эскапортлох боломжтой. Гэсэн хэдий ч органик гоо сайхны бүтээгдэхүүн, сарлаг болон ботгоны ноос, чацарганы тос болон арьс ширийг тус зах зээлд гаргаж байгаа. Тодруулбал, Монгол Улс өнгөрсөн онд 13 тэрбум ам.долларын гадаад худалдаа хийснээс 7 тэрбум нь экспорт байжээ. Гэхдээ Европын холбооны зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүнээс 100 сая ам.доллар олсон нь хэт бага үзүүлэлт. Европын холбооноос нийт 4.5 сая еврогийн санхүүжилт бүхий ТРАМ төслийг 2017 оны гуравдугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. ТРАМ бол бизнесийн салбарын хууль эрх зүйн орчныг үнэлэх, зөв, оновчтой болгох, шинэ санал санаачилгыг дэмжих зэрэг худалдааны тогтвортой бодлого боловсруулах болон кластерийг хөгжүүлэх зорилготой төсөл юм.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 6-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 6-р сар 2019 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn